



**НИЙСЛЭЛИЙН НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН ТУСГАЙ ТӨВИЙН
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 11 сарын 23 өдөр

Дугаар А/26

Улаанбаатар хот

Ковид-19 цар тахлын халдвараас сэргийлэх
бүх нийтийн бэлэн байдлын горимд шилжсэнтэй холбогдуулан
нэмэлт ажилтан ажиллуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэр, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 178 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/1242, А/1247 дугаар захирамж, Нийслэлийн Онцгой комиссын 14, 15 дугаар хуралдааны тэмдэглэл, төвийн даргын 2019 оны А/10 тоот тушаалаар баталсан "Нийгмийн хамгааллын тусгай төвийн хөдөлмөрийн дотоод журам"-ын 4.5, 10.8 дахь заалт, төвийн даргын дэргэдэх зөвлөлийн 2020 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. 2020 оны 11 дүгээр сарын 12-ны өдрөөс эхлэн шинэ коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх, бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан гэр оронгүй иргэдийг тус төвд байршуулах, халдвар хамгааллын даглэмийг чанд мөрдүүлэхэд ажлын ачаалал нэмэгдэж, иргэдийн гарах хөдөлгөөнийг хязгаарлан, хөл хорио тогтоох шаардлага үүссэн тул 2020 оны 11 дүгээр сарын 17-ны өдрөөс Дамдин овогтой Зулхүү, Жудалдай овогтой Түмэн-Өлзий, Ганжууржав овогтой Цэдэндамба нарыг нэмэлт жижүүрээр, Батсүрэн овогтой Азжаргалыг гал тогооны бэлтгэгчээр тус тус түр томилон ажиллуулсугай.

2. Нэмэлтээр ажилласан ажилтнуудын цалинг хуваарийн дагуу тооцож, Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/1247 дугаар захирамжаар олгосон арга хэмжээний зардлаас тооцон олгохыг нягтлан бодогч Б.Энхдэлгорт зөвшөөрсүгэй.

3. Шинэ коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх бүх нийтийн бэлэн байдлын үед хариуцлагатай байж, төвийн ажилтнуудтай хамтран ажиллахыг дээрх ажилтнуудад анхааруулсугай.

ДАРГА



Г.ЦЭРЭНДУЛАМ

318060303